



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
БОЛОВСРОЛЫН ГАЗАР

Багшийн хөгжлийн ордон, Энхтайваны өргөн чөлөө 10а,
11 дүгээр хороолол, 8 дугаар хороо,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14191
Утас/Факс: (976) 7011-3033
<http://www.edub.edu.mn>

2019.02.02 № 01/152
танай _____-ны № _____-т

ДҮҮРГИЙН БОЛОВСРОЛЫН
ХЭЛТСИЙН ДАРГА НАРТ

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын
“Арга хэмжээ авч ажиллах тухай” 2019 оны 02 дугаар
сарын 01-ний өдрийн тушаалыг хавсралтаар хүргүүлж
байна.

Тус тушаалыг ерөнхий боловсролын сургууль,
цэцэрлэгт хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж
ажиллана уу.

Хавсралт: 1 хуудас

ДАРГА



Ж.ГАНТУЛГА

1150500160



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
САЙДЫН ТУШААЛ

2019 оны 02 сарын 01 өдөр

Дугаар А/57

Улаанбаатар хот

Арга хэмжээ авч, ажиллах тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Бага, дунд боловсролын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ерөнхий боловсролын сургуулийн 3 дугаар улирлын хичээлийг тогтоосон хугацаанд эхлүүлэх нөхцөлийг хангах зорилгоор аймаг, нийслэлийн Засаг дарга нарт дараах арга хэмжээ авч, ажиллахыг үүрэг болгосугай.

1.1. Цагаан сарын үеэр суралцагчдыг томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар эцэг эх, олон нийтэд тайлбарлан таниулах үйл ажиллагаа зохион байгуулахыг боловсрол, сургалтын байгууллагын нийт албан хаагчдад үүрэг болгох.

1.2. Цагаан сарын үеэр боловсрол, сургалт, соёлын байгууллагын ажилтан, албан хаагчид, суралцагчид, эцэг эхийг хамруулсан аливаа үзвэр үйлчилгээ, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулахгүй байх шийдвэр гаргах, хяналт тавьж ажиллах, болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх талаар холбогдох арга хэмжээг шуурхай авах.

2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /З.Энхболд/-т даалгасугай.



0900175